

4/20-НЫ ӨДРИЙН ИРЦИЙН МЭДЭЭ:

		Нийт	Урьдчилж өгсөн санал	4/20-ны ирц
1	Хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийн тоо	897	829	68
2	Хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийн саналын эрхийн тоо	690,411,864	284,381,205	406,030,659
3	Ирцийн хувь	88.50%	36.45%	52.05%

САНАЛЫН ХУУДСЫН МЭДЭЭ:

		Ширхэг	Хувьцааны тоо	Саналын эрх
<b>1</b>	<b>Нийт санал</b>	<b>894</b>	<b>690,411,864</b>	<b>88.50%</b>
1.1	Санал хураах хайрцгаар дамжуулан ирүүлсэн	65	406,030,659	52.05%
1.2	Урьдчилж ирүүлсэн	829	284,381,205	36.45%
1.2.1	Шуудангаар дамжуулан ирүүлсэн	1	265,238,300	34.00%
1.2.2	Үнэт цаасны компаниар дамжуулан ирүүлсэн	2	18,662,252	2.39%
1.2.3	Компани дээр шууд ирүүлсэн	826	480,653	0.06%
<b>2</b>	<b>Саналын хуудсаа ирүүлээгүй</b>	<b>3</b>	<b>15,701</b>	<b>0.00%</b>
<b>3</b>	<b>Хүчингүй болсон саналын хуудас</b>	<b>48</b>	<b>92,203</b>	<b>0.01%</b>
3.1	Энгийн аргаар тоолох санал	1	500	0.00%
3.2	Кумулятив аргаар тоолох санал	47	91,703	0.01%
<b>4</b>	<b>Хүчинтэй саналын хуудас</b>	<b>846</b>	<b>690,303,960</b>	<b>88.49%</b>
4.1	Энгийн аргаар тоолох санал	893	690,395,663	88.50%
4.2	Кумулятив аргаар тоолох санал	847	690,304,460	88.49%

САНАЛ ХУРААЛТЫН ДҮН:

№	Хэлэлцсэн асуудлууд	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах	99.9942%	0.0039%	0.0020%
2	ТУЗ-ийн гишүүдийн цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох	99.9727%	0.0243%	0.0031%
3	ТУЗ-ийн 2023 оны цалингийн төсвийг батлах	99.9911%	0.0058%	0.0031%
4	ТУЗ-ийн гишүүдийг батлах	Дэмжсэн кумулятив саналын тоо		Хувь
	4.1 ТУЗ-ийн хараат бус гишүүд			
1	Д.Гэрэлмаа		424,858,099	6.84%
2	А.Жаргалмаа		424,468,495	6.83%
3	Т.Камбэ		1,486,623,366	23.93%
4	Д.Хүрэлбаатар		424,471,902	6.83%
	4.2 ТУЗ-ийн ердийн гишүүд			
5	Ц.Баатарсайхан		425,760,876	6.85%
6	Х.Савада		1,750,746,457	28.18%
7	Д.Хулан		424,773,669	6.84%
8	Б.Амарсайхан		426,150,939	6.86%
9	Ц.Оргилболд		424,879,424	6.84%
	Нийт кумулятив саналын эрхийн хэмжээ		6,212,740,140	100.00%

Тооллогын комиссын дарга

Нарийн бичгийн дарга

Гишүүд



Н.САЙНЗУЛ

Ц.ЦЭЦЭГБАДАМ

Т.МӨНХЗУЛ

Б.УЯНГА

Г.ГАНЗАЯА

Г.УУХАНЗАЯА

2023.04.20



MONGOLIAN CASHMERE

ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИ  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН  
ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Хурлын ирцийн тухай

Говь ХК-ийн 2023 оны 4-р сарын 20-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийг хурлын даргад мэдээлэх нь:

**Нэг.** Говь ХК-ийн 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх бүртгэлийн өдөр нь 2023 оны 3-р сарын 31-ний өдөр байсныг дурдсугай.

**Хоёр.** Бүртгэлийн өдрөөр Говь ХК-ийн нийт саналын эрхтэй хувьцааны тоо **780,112,500** ширхэг байснаас хурлын материалтай урьдчилан танилцан санал өгөх арга хэлбэрээр **284,381,205 (36.45%)** саналын эрхтэй **829** хувьцаа эзэмшигч, 4-р сарын 20-ны өдрийн хуралд биечлэн оролцох арга хэлбэрээр **406,030,659 (52.05%)** саналын эрхтэй **68** хувьцаа эзэмшигч оролцсоноор нийт ирц **88.50** хувь болж, хурлын ирц бүрдсэнийг мэдэгдсүгэй.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
ГИШҮҮД



Н.САЙНЗУЛ

Ц.ЦЭЦЭГБАДАМ

Т.МӨНХЗУЛ

Б.УЯНГА

Г.ГАНЗАЯА

Г.УУГАНЗАЯА



MONGOLIAN CASHMERE

ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИ  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН  
ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Г Санал хураалтын нэгтгэсэн дүнгийн тухай Г

Монгол улсын Компанийн тухай хуулийн 67.3, Говь ХК-ийн дүрмийн 6.1.10-6.1.16 заалтыг удирдлага болгон хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын санал хураалтын дүнг нэгтгэн тоолсныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

**Нэг.** Нийт **88.50** хувийн саналын эрхтэй **690,411,864** ширхэг хувьцааны **894** ширхэг саналын хуудас хураасныг тооцсугай.

**Хоёр.** 2023 оны 4-р сарын 20-ны өдөр санал хураах хайрцгаар **52.05** хувийн саналын эрхтэй **406,030,659** ширхэг хувьцааны **65** ширхэг саналын хуудас хураасныг дурдсугай.

**Гурав.** Урьдчилж ирүүлсэн саналын хуудасны хувьд шуудангаар дамжуулж **34.00** хувийн саналын эрхтэй **265,238,300** ширхэг хувьцааны **1** ширхэг саналын хуудас, үнэт цаасны компаниар дамжуулж **2.39** хувийн саналын эрхтэй **18,662,252** ширхэг хувьцааны **2** ширхэг саналын хуудас, компанийн байранд **0.06** хувийн саналын эрхтэй **480,653** ширхэг хувьцааны **826** ширхэг саналын хуудас тус тус урьдчилж ирүүлснийг дурдсугай.

**Дөрөв.** Нийт саналын хуудаснаас **0.01** хувийн саналын эрхтэй **92,203** ширхэг хувьцааны **48** ширхэг саналын хуудас хүчингүй болсныг дурдсугай.

**Тав.** Говь ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг хуралд оролцогчдын саналын эрхийн олонхоор буюу **99.99** хувийн саналаар баталсныг мэдэгдсүгэй.

**Зургаа.** Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай асуудлыг хуралд оролцогчдын саналын эрхийн олонхоор буюу **99.98** хувийн саналаар баталсныг мэдэгдсүгэй.





MONGOLIAN CASHMERE

**“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2023 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

**Компанийн 2022 оны үйл ажиллагааны  
болон санхүүгийн тайланд өгөх ТУЗ-ийн  
дүгнэлтийг батлах тухай**

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Компанийн дүрмийн 6.1.9.10 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон Говь ХК-ийн 2022 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс компанийн үйл ажиллагаанд өгсөн дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2023 оны 04 сарын 20-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ нь:**

**Нэг.** Говь ХК-ийн 2022 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг Хавсралт 1 ёсоор баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.ГЭРЭЛМАА



## ГОВЬ ХК-ИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГӨХ ДҮГНЭЛТ

Говь ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх дүгнэлтийг Компанийн тухай хууль, Говь ХК-ийн дүрмийн хүрээнд Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх)-ийн хурлаар хэлэлцэн, тус компанийн Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байна.

ТУЗ-ийн зүгээс Говь ХК-ийн нийт хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг төлөөлөн компанийг удирдах үйл ажиллагаандаа Сайн засаглалын зарчмууд, Компанийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж болон Хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан дүрмийг мөрдлөг болгож ажиллаж ирлээ. ТУЗ нь тус компанийн 2022 оны бизнес төлөвлөгөө болон үйл ажиллагааны зорилтыг хэлэлцэн баталж, хэрэгжилт дээр нь тогтмол хяналтыг тавин, компанийн гүйцэтгэх удирдлагын багийг санал зөвлөмж, үүрэг даалгавраар ханган чиглүүлж ажилласан бөгөөд Гүйцэтгэх удирдлагын баг нь ТУЗ-ийн баталсан төлөвлөгөө зорилт, шийдвэр, санал зөвлөмж, үүрэг даалгаврыг амжилттай хэрэгжүүлэн ажилласан.

ТУЗ-ийн баталсан 2022 оны бизнес төлөвлөгөө болон үйл ажиллагааны зорилт нь компанийн нийт борлуулалтын орлогыг өмнөх оноос 55% өсгөх, ашигт ажиллагааг сайжруулан бохир ашгийн түвшинг 50%-д барих, онлайн зах зээлийн маркетингийн зардлыг оновчтой зарцуулан CPNC буюу шинээр нэг харилцагчийг татах зардлыг өмнөх оноос 80% бууруулж Европын зах зээлд 10 евро, Америкийн зах зээлд 15 ам.долларт хүргэх, компанийн программ хангамжийг хөгжүүлж, дата өгөгдлийг цахимжуулан автоматжуулж ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, тогтвортой хөгжлийн үйл ажиллагааг хөгжүүлэн өргөжүүлэх, хүн хүчний тогтвортой бодлого баримталж, ажилтнуудыг чадавжуулах, шинэ технологийн инновац шингэсэн бүтээгдэхүүнийг тасралтгүй хөгжүүлж үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд тус тус чиглэсэн билээ.

Санхүүгийн үр дүнгийн хувьд 2022 онд 193.4 тэрбум төгрөгийн борлуулалтыг хийж, бизнес төлөвлөгөөний биелэлт 82% гүйцэтгэлтэй буюу өмнөх оноос 34% өссөн үзүүлэлттэй гарлаа. Дотоод борлуулалт 93.5 тэрбум төгрөг болж төлөвлөгөөний биелэлт 99%, өмнөх оноос 40% өссөн, экспортын борлуулалт 45.6 тэрбум төгрөг болж төлөвлөгөөний биелэлт 154%, өмнөх оноос 24% өссөн, онлайн борлуулалт 54.3 тэрбум төгрөг болж төлөвлөгөөний биелэлт 55%, өмнөх оноос 33% өссөн үр дүнд хүрчээ. Энэ онд өмнөх онтой харьцуулахад алдагдлын хэмжээгээ 82% бууруулж 7.0 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан бөгөөд бохир ашгийн түвшинг 49%-д хүргэн өмнөх оноос 8%-иар нэмэгдүүлж чадсан. Мөн түүхийг

эд татан авалтыг хамгийн бага түвшинд хийж, нөөцөө бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлснээр бараа материалын эргэцийг 29% бууруулж чадсан.

Энэ онд нийт 3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийснээс 1.6 тэрбум төгрөг буюу 55% нь барилга байгууламж, 230 сая төгрөг буюу 8% нь тоног төхөөрөмж, 926 сая төгрөг буюу 31% нь тавилга эд хогшил болон бусад биет хөрөнгө оруулалтад, 189 сая төгрөг буюу 6% нь биет бус хөрөнгө оруулалтад зарцуулагдсан байна.

Дэлхийн зах зээлийг чиглэн онлайнаар бүтээгдэхүүнээ борлуулахын тулд эхний жилүүдэд Говь брэндийг дэлхийн хэрэглэгчдэд таниулах зорилгоор маркетингийн зардлын зарцуулалт өмнөх 2 жилд өндөр байсан бол 2022 онд өмнөх оноосоо 28% бууруулсан бөгөөд нэг харилцагчийг татах дундаж зардлыг Европын зах зээлд 15 евро болгон 3.1 дахин бууруулж чадсан. Мөн нийт бүртгэлтэй хэрэглэгчдийн тоог өмнөх оноос 400 мянгаар нэмэгдүүлж 653 мянгад хүргэсэн.

Компанийн программ хангамжийг хөгжүүлж, дата өгөгдлийг цахимжуулан автоматжуулах зорилгын хүрээнд хууль, гэрээний цахим систем, төлбөр, худалдан авалтын цахим систем, шүгэл үлээх тогтолцооны цахим системийг дотооддоо хөгжүүлэн ашиглалтад оруулж, компанийн хэмжээнд MS Teams-ийг нэгдсэн байдлаар нэвтрүүлж, анхан шатны үйлдвэрийн программ хөгжүүлэлтийг 91%-ийн гүйцэтгэлтэй хийснээр ажилтнуудын цагийг хэмнэх, бүтээмжийг нэмэгдүүлэхэд сайн үр нөлөөг үзүүлж чадлаа.

Мөн тогтвортой хөгжлийн үйл ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх зорилгоор ТУЗ-өөс "Тогтвортой хөгжлийн үүрэг амлалт"-ыг баталсан бөгөөд тус үүрэг амлалтын хүрээнд Тогтвортой хөгжлийн бодлого, зорилтуудаа тодорхойлон баталж, хэрэгжилтийг нь ханган ажиллалаа. Түүнчлэн ажилтнуудынхаа тав тухтай сэтгэл ханамжтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор бүтээмж, гүйцэтгэлд суурилсан цалингийн системийг шат дараатай нэвтрүүлж, ажилтнуудаа дотоод болон гадаад эх үүсвэрээс 130 орчим сая төгрөгийн сургалтад хамруулж, ажилтнуудынхаа хүүхдүүдэд зориулсан цэцэрлэгийн үйл ажиллагааг амжилттай эхлүүллээ.

Иймд Говь ХК-ийн гүйцэтгэх удирдлагын баг 2022 онд төлөвлөсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглан ажилласан гэж Төлөөлөн удирдах зөвлөлөөс дүгнэж байна.

## **ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ**



MONGOLIAN CASHMERE

**“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2023 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

*Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
гишүүдийн цалингийн хэмжээг  
шинэчлэн тогтоох тухай*

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, Компанийн дүрмийн 6.1.9.12 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны зүгээс оруулсан санал болон 2023 оны 04 сарын 20-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ нь:**

**Нэг.** Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн цалинг тогтмол цалин болон гишүүдийн оролцоонд үндэслэсэн оролцооны цалингаас бүрдэхээр тогтоосугай.

**Хоёр.** ТУЗ-ийн гишүүдийн тогтмол цалин болон оролцооны цалингийн хэмжээг дараах байдлаар шинэчлэн тогтоосугай.

ТУЗ-ийн гишүүдийн цалин		Шинэчилсэн цалин /төгрөг/
Тогтмол цалин	Үндсэн	1,400,000
	ТУЗ-ийн даргын нэмэгдэл	1,000,000
	Хорооны даргын нэмэгдэл	400,000
Оролцоонд үндэслэсэн цалин	Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн хурал, ТУЗ-ийн дэргэдэх хороодын хуралд оролцсон тоогоор	650,000

**Гурав.** ТУЗ-ийн гишүүдийн тогтмол цалинг сар бүр, оролцооны цалинг Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн хурал, ТУЗ-ийн дэргэдэх хороодын хуралд оролцсон оролцоонд үндэслэн тооцож, улиралд нэг удаа олгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.ГЭРЭЛМАА





MONGOLIAN CASHMERE

**“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2023 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
2023 оны цалингийн төсвийг  
батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, Компанийн дүрмийн 6.1.9.12 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон 2023 оны 04 сарын 20-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

**Нэг.** Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны цалингийн төсвийг дараах байдлаар баталсугай.

Агуулга	Тогтмол цалин /төгрөг/	Оролцоонд үндэслэсэн цалин /төгрөг/	Нийт цалин /төгрөг/
ТУЗ-ийн гишүүдийн цалин	161,200,000	41,800,000	203,000,000

**Хоёр.** Батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Цалин, урамшууллын хороонд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.ГЭРЭЛМАА



MONGOLIAN CASHMERE

**“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2023 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
гишүүдийг батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 77 дугаар зүйлийн 77.1, 77.4, Компанийн дүрмийн 6.1.9.8, 6.2.3 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон 2023 оны 04 сарын 20-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ нь:**

**Нэг.** Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа дуусгавар болж буйг дурдсугай.

**Хоёр.** Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдээр:

Дамбын ГЭРЭЛМАА  
Алтангэрэлийн ЖАРГАЛМАА  
Такэши КАМБЭ  
Дамбийжавын ХҮРЭЛБААТАР нарыг;

Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүдээр:

Цагаачийн БААТАРСАЙХАН  
Хидэо САВАДА  
Дашдаваагийн ХУЛАН  
Баатарсайханы АМАРСАЙХАН

Цогтгэрэлийн ОРГИЛБОЛД нарыг тус тус 3 (гурван) жилийн хугацаагаар сонгон томилсугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.ГЭРЭЛМАА